



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 244

Улаанбаатар хот

“Дэу Секьюритис Монгол” ХХК-д гадаад улсын
үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах
үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 36.16, Хорооны 2014 оны 7 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны тухай журам”-ын 9¹ дэх заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Дэу Секьюритис Монгол” ХХК-ийг гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон дүрэм, журмыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг “Дэу Секьюритис Монгол” ХХК /Ким На Хван/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000252